

Хүүхдэд зориулсан Библи
танилцуулж байна

Бурхан
Абрахамын
хайрыг
шалгасан
нь



Зохиогч: Edward Hughes

Зураглаач: Byron Unger; Lazarus

Найруулсан: M. Maillot; Tammy S.

Орчуулсан: Damdin Norolsuren

Бүтээсэн: Bible for Children

www.M1914.org


©2014 Bible for Children, Inc.

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.**



Нэгэн
шөнө Бурхан
Абрахамд маш
хэцүү зарлиг
буулгажээ.



An illustration of an elderly man with white hair and a beard, wearing a red robe with white stripes on the sleeves, looking out over a landscape. The landscape features green hills, a dark body of water with rocks, and a bright yellow sun in a dark blue sky with rays of light. The text is overlaid on the right side of the image.

Энэ нь Бурхан
Абрахам хүү
Исаакаатаа Бурхнаас
илүү хайртай эсэхийг
шалгасан Бурхны

сорилт
байлаа.



"Хүү Исаакаа аваад
түүнийг шатаалт
тахилд өргө"
хэмээн Бурхан
айлдав.



Исаакаар тахил
өргө? Өөрийн
хүүгээ тахилд
өргөх гэж үү?



Абрахамд маш хүнд
байлаа. Тэр өөрийн
хүүдээ маш их
хайртай байв.



**Гэвч Абрахам
сайн ойлгоогүй ч
Бурханд итгэж байв.**



Өглөө эртлэн тахилд
бэлдээд Исаак болон
хоёр зарцаа дагуулан

уул уруу

явлаа.



**Явахынхаа өмнө
шатаалт тахилын
модыг бэлдээд
авч явлаа.**




Абрахам Бурхныг
дуулгавартай
дагахаар
шийджээ.



Гурван өдрийн
дараа тэд ууланд
хүрэв.





Абрахам "Энд
хүлээж бай" гэж хоёр
зарцдаа хэлээд "Бид
мөргөл үйлдээд

та нар уруу
буцаж ирэх
болно"


ГЭВ.



**Исаак шатаалт
тахилын модыг үүрэн
Абрахам гал болон
хутгаа авлаа.**



**Исаак хүү "Шатаалт
тахилын хурга нь
хаана байгаа юм бэ?"**



**ГЭЖ ЭЦГЭЭСЭЭ асуув.
"Бурхан өөрөө
хангах болно" гэж
Абрахам хариулав.**



**Тэд явсаар
Бурхны
сонгосон
газарт ирэв.**



**Тэнд Абрахам
шатаалт тахилыг
ширээ босгоод
дээр нь ...**



**... модоо өрөөд
Бурханд тахил
өргөхөд бэлэн
болов.**



**Абрахам олон
удаа тахилын ширээ
босгож байсан ч энэ
удаа хамгийн хэцүү
байлаа.**



**Абрахам Исаакийн гарыг
хүлээд өөрийн хайртай
хүүгээ тахилын ширээн
дээр тавив.**



**Абрахам үнэхээр Бурханд
дуулгавартай байж өөрийн
цорын ганц хүүгээ тахил
болгон өргөсөн болов
уу?**



**Тийм ээ!
Абрахам
хутгаа сугалаад
гараа далайв.**



**Түүний
зүрх хүчтэй
цохилж байсан ч
Абрахам Бурханд
дуулгавартай
байхыг л мэдэж
байв.**





"Болъ!"
Түүнд
юу ч бүү
хий! гэж
Тэнгэр элч
өгүүлрүүн.



**"Учир нь
чи хүүгээ,
цорын ганц
хүүгээ
Надаас
харамлаагүй
тул
чамайг ...**



**... Бурханаас
ЭМЭЭДГИЙГ
ЧИНЬ ОДОО
БИ МЭДЛЭЭ
ГЭВ."**



Абрахам бутан
дунд нэгэн хонь
байхыг хараад
Исаакийн ...



**... ХҮЛЭЭСИЙГ ТАЙЛЖ
ӨНӨӨХ ХОНЫГ
ШАТААЛТ ТАХИЛ
БОЛГОН ӨРГӨВ.**



**Тэр Үед Исаак аавын
хэлснээр Бурхан
өөрийгөө хангалаа
гэж бодоо бизээ.**



Эцэг хүү хоёр мөргөл өргөхөд тэнгэр
элч Абрахамд "Чи дуулгавартай

байсан учир чиний үр
хүүхдээр дамжуулан бүх
үндэстэн ерөөгдөх
болно"
ГЭВ.



**Абрахамын удмаас хэзээ
нэгэн цагт Есүс төрөх
ёстой байлаа.**



**Абрахам Исаакийг дагуулан гэртээ
харилаа. Хэдэн өдрийн дараа
гунигтай зүйл тохиолдов.**



**Эхнэр Сара нь нас баржээ. Абрахам
эхнэрээ Исаак ээжээ алдав.**



Түүнийг
оршуулсны
дараа, ...



**... Абрахам
ахлах зарцаа
Исаакт тохирох эхнэр
олуулахаар явуулав.**



Зарц

Абрахамын

хамаатнуудыг олохоор

тэдний хуучин нутагт ирэв.



Зарц нь Бурхнаас тэмдэг үзүүлэхийг хүсэв. "Миний тэмээг услахаар ирэх охин Исаакт тохирох нэгэн мөн" гэв.



Гэнэт Ребека хүрч ирээд
ТЭМЭЭНҮҮДИЙГ тань усалъя гэв.



**Тэр охин Абрахамын хамаатнуудын
нэг байв. Зарц Бурхан түүний
залбиралд хариулсныг мэдэв.**



**Ребека Исаактай гэрлэхийн тулд гэр
бүлээ орхин гарлаа.**



**Тэр Исаакийг ээжийнх нь үгүйд
түүнийг тайвшруулжээ.**



**Исаак түүнийг ямар их
хайрласан бол!**



Бурхан Абрахамын хайрыг шалгасан нь

Бурханы үг Библиээс авсан түүх

Эхлэл 22-24

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



Төгсөв



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг
бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж
хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж
хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь
үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир
Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн
өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг
зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс
дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та
Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал
гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр
таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн
та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.



**Хэрвээ та энэ үнэнд итгэж
байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй:
Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон
миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та
амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж
ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос
эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр
тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд
дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө
амьдрахад туслаач. Амен.**

**Библи уншиж өдөр бүр Бурхантай
ярилцаарай! Иохан 3:16**

